

## ТАНИЛЦУУЛГА

*Усны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулга*

### **1.Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, өөрчлөн найруулах, үг, өгүүлбэрийг хасах, хүчингүй болсонд тооцох болсон үндэслэл, шаардлага**

Монгол Улсын Үндсэн хуулийн 6.1 дэх заалтад “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна” гэж, мөн 6.2 дахь заалтад “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах” гэж, мөн хуулийн 16.2 дахь заалтад Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ гээд “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж тунхаглажээ.

Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3.1 дэх заалтад “Энэ хуулиар байгалийн дор дурдсан объектыг байгаль орчинд хортой нөлөөлж болзошгүй үйл ажиллагаанаас хамгаалж, байгаль орчны тэнцэл алдагдахаас сэргийлнэ: 1/газар, түүний хөрс; 2/газрын хэвлий, түүний баялаг; 3/ус” гэж мөн хуулийн 3.2 дахь заалтад ““ус” гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэр дэх мөрөн, гол, горхи, булаг, шанд, рашаан, мөнх цас, мөс, мөсөн гол, байгалийн болон хиймэл нуур, цөөрөм зэрэг газрын гадаргын болон газрын доорх ус хамаарна” гэж, мөн хуулийн 3.2.7 дахь заалтад “байгаль орчныг хамгаалах” гэдэгт байгаль орчныг бохирдохоос урьдчилан сэргийлэх, байгалийн баялгийг жам ёсоороо нөхөн сэргэх боломжийг нь алдагдуулахгүйгээр, байгалийн даацад нь тохируулан зохистой ашиглах, нөхөн сэргээх, тэдгээрт хяналт тавих ажиллагаа хамаарна” гэж заасан.

Усны тухай хуулийн 3.1.9 дахь заалтад “онцгой болон энгийн хамгаалалтын бүс” гэдэгт усны сан бүхий газар, усны эх үүсвэр, рашааны ордыг хомсдох, бохирдохоос хамгаалах зорилгоор тогтоосон зурвас газрыг”, мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт “Усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, үер, усны гамшгаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, усны эх үүсвэрт онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс тогтооно”, мөн хуулийн 22.2 дахь хэсэгт “Усны сан бүхий газрын эргээс 50 метрээс доошгүй зайд болон гол мөрний татамд онцгой хамгаалалтын бүс тогтооно.” гэж, 22.2.1 дэх заалтад “онцгой хамгаалалтын бүсэд барилга, байгууламж барих, газар хагалах, тэсэлгээ хийх, газар тариалан эрхлэх, ашигт малтмал хайх, олборлох, зэгс, шагшуурга, мод огтлох, элс, хайрга, чулуу авах, байгалийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх, мал угаах болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цэг байгуулахыг хориглоно.” гэж заасан.

Улсын их хурлаар 2025 оны 7 дугаар сарын 9-ны өдөр батлагдсан Усны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Усны тухай хуулийн 22

дугаар зүйлийн 22.2.1 дэх заалтын "бүсэд" гэсний дараа "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 5.1.8-д зааснаас бусад" гэж нэмсүгэй" гэжээ.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 5.1.8 дахь заалтад "нийтийн зориулалттай дэд бүтэц" гэж нийтэд зориулсан төрийн үйлчилгээний барилга байгууламж, авто зам, төмөр зам, дүүжин зам, газрын дээр, доор байрлах замын байгууламж, бүх төрлийн инженерийн шугам сүлжээ, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх энгийн болон инженерийн хийц, бүтээц бүхий байгууламжийг" гэжээ.

Барилгын тухай хуулийн 4.1.1 дэх заалтад "барилга байгууламж" гэж орон сууц, иргэн, үйлдвэр, эрчим хүч, харилцаа холбоо, ус, нефтийн барилга, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж түүний инженерийн шугам сүлжээг ойлгоно" гэсэн. Барилгын тухай хууль болон салбарын ухагдахуунаар нийтийн зориулалттай барилга байгууламж болон ердийн барилга байгууламжийн барих процесс нь функциональ шинж чанараар ялгарахгүй, газар шорооны ажил, суурийн цутгалт, карказ цутгалт, цонх, хана, дээврийн ажил гэх мэт ажлууд барилгын технологийн хувьд төстэй билээ. Тиймээс нийтэд зориулсан төрийн үйлчилгээний барилга байгууламж нь усны онцгой хамгаалалтын бүсэд баригдвал ердийн барилга байгууламж барихтай адилхнаар усны сан бүхий газрыг бохирдуулах, усны нөөцөд сөргөөр нөлөөлнө.

Дээр дурдсанчлан Усны тухай хуульд өөрчлөлт орсноор Монгол орны усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой хамгаалалтын бүсэд нийтийн зориулалттай барилга байгууламж барих үүд хаалгыг нээж, байгаль орчин, усны нөөцийн хамгаалах зайлшгүй хэрэгцээ бий болоод байна.

Иймд хуулийн төслийг 2 зүйлтэй байхаар боловсрууллаа.

## **2.Зохицуулахаар тусгасан харилцааны агуулга, зохицуулалтыг хэрхэн ойлгох тухай**

Усны тухай хуулийн онцгой хамгаалалтын бүсэд аливаа барилга байгууламжийг барих явдлыг хориглосон байгаа нь тухайн барилга байгууламжийг хэн ямар зориулалтаас ашиглахаас үл хамаарна.

Монгол улсын иргэд эрүүл аюулгүй орчинд амьдрах, улс орнууд тогтвортой хөгжихийн үндэс, аюулгүй байдлын баталгаа бол "УС" юм.

Чандмань эрдэнэ болсон усаа ариг гамтай, зүй зохистой хэрэглэхийг ёс зүйгээр болон хуулиар зохицуулж ирсэн нандин сайхан уламжлал манайд бий. Тухайлбал, "Халх журам" хуульд "Мэдсээр байж шоглож ус бохирдуулбал шүглэн морь, үхэр хоёр ав. Үзсэн гэрчид үхэр өг", "Хүний шинэ ухсан, зассан усыг булаацалдан маргавал нэг хязаалан хонь ав. Өөрийн малыг усалж дуусаад усаа эс өгвөөс мөн нэг морь ав" хэмээн усыг хэрхэн зохистойгоор хамтарч ашиглахыг мөн иргэн хүний эрх үүрэг, оролцоо ямар байх ёстойг зохицуулан хуульчилж байжээ.

Хуулийн төсөл батлагдсанаар монгол улсын Үндсэн хуульд зааснаар газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байх Үндсэн хуулийн зохицуулалтыг амьдралд хэрэгжүүлэх, байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд

амьдрах эрхийг нь баталгаажуулж, хууль дээдлэх зарчмыг хангахад эерэг нөлөө үзүүлнэ.

Иймд усны онцгой хамгаалалтын бүсэд нийтийн зориулалттай дэд бүтэц гэж нийтэд зориулсан төрийн үйлчилгээний барилга байгууламж, авто зам, төмөр зам, дүүжин зам, газрын дээр, доор байрлах замын байгууламж, бүх төрлийн инженерийн шугам сүлжээ, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх энгийн болон инженерийн хийц, бүтээц бүхий байгууламжийг барих хориглох зохицуулалтыг тусгаж хуулийн төслийг боловсрууллаа.

--- оОо ---

**ТАНИЛЦУУЛГА**

*Усны тухай хуульд өөрчлөлт оруулах  
тухай хуулийн төслийн товч  
танилцуулга*

**1.Хуулийн төслийн ерөнхий агуулга, зохицуулах харилцаа, хуулийн төсөлд тусгасан зарчмын шинжтэй зохицуулалтын талаар**

Усны онцгой хамгаалалтын бүсэд нийтийн зориулалттай дэд бүтэц гэж нийтэд зориулсан төрийн үйлчилгээний барилга байгууламж, авто зам, төмөр зам, дүүжин зам, газрын дээр, доор байрлах замын байгууламж, бүх төрлийн инженерийн шугам сүлжээ, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх энгийн болон инженерийн хийц, бүтээц бүхий байгууламжийг барих хориглох зохицуулалтыг тусгаж хуулийн төслийг боловсрууллаа.

**2.Тухайн харилцааг урьд нь хууль, эрх зүйн бусад актаар зохицуулж ирсэн байдал**

Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт “Усны сан бүхий газрын эргээс 50 метрээс доошгүй зайд болон гол мөрний татамд онцгой хамгаалалтын бүс тогтооно.” гэж, 22.2.1 дэх заалтад “онцгой хамгаалалтын бүсэд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 5.1.8-д зааснаас бусад барилга, байгууламж барих, газар хагалах, тэсэлгээ хийх, газар тариалан эрхлэх, ашигт малтмал хайх, олборлох, зэгс, шагшуурга, мод огтлох, элс, хайрга, чулуу авах, байгалийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх, мал угаах болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цэг байгуулахыг хориглоно.” гэж заасан.

Дээр дурдсанчлан нийтэд зориулсан төрийн үйлчилгээний барилга байгууламжийг усны онцгой хамгаалалтын бүсэд барьснаар, онцгой хамгаалалтын дэглэм алдагдах, хамгаалалтын зохицуулалт зөрчигдөх эрсдэлтэй байна.

**Хуулийн төсөл боловсруулахтай холбогдуулан хууль санаачлагчаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ**

Хуулийн төслийг боловсруулахын тулд хууль Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу төслийн үр нөлөөний үнэлгээг хийж, төслийн хэрэгцээ шаардлагыг тандан судалж, олон нийтэд нээлттэй хэлэлцүүлэг хийлээ.

**4.Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн дүн**

Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн бөгөөд тодорхой санал ирээгүй болно.